

## ЭРДЭНЭЦАГААН СУМ

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН МЭДЭЭ

### **Хууль, эрх зүй, удирдлага зохион байгуулалтын хүрээнд:**

Монгол Улсын төрийн хяналт шалгалтын тухай хууль, ХХАА,Хөнгөн Үйлдвэрийн яамны улсын ерөнхий байцаагчийн 2023 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн 08-00/01 дугаартай “Хяналт шалгалтын удирдамж”-ын дагуу Улсын баяр наадмыг тохиолдуулан урьчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулсан. Үүний дагуу Сумын Засаг даргын Тамгын газрын даргаар “2023 оны 07 дугаар сарын 05”-ны өдрийн 03-02 дугаар бүхийн хяналт шалгалтын удирдамж батлуулан ажилласан. Татварын улсын байцаагч, Цагдаа, ГУА-47 дугаар ангийн төлөөлөлтэй хамтран 21 цэгт очиж ажилласан. Удирдамжаар ажиллахдаа “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжийн дарга захирлуудад 10 заалт бүхий зөвлөмжийг бэлтгэн хүргэсэн. Аймгийн ЭМГ-ын даргын 2023.07.04-ны өдрийн 383 дугаартай Баяр наадмын үеэр үйл ажиллагаа явуулж буй хүнсний худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгч нарт “Зөвлөмж хүргүүлэх тухай”, ЭМГ-ын улсын байцаагчийн 2023.05.17-ны өдрийн 10-28-01-/109/01 Хүнсний худалдаа үйлчилгээ эрхлэгч нарт “Эрсдэлээс урьдчилан сэргийлэх тухай бичгүүдийг хүргэж, түүний дагуу хяналт шалгалтыг хийж ажилласан. Хоршоодын гишүүдийг туршлага судлах арга хэмжээнд Хөх хавцал хоршооны гишүүн М.Сэрүүнтунгалагын мэдээллийг өгч “Хоршоологчид тогтвортой хөгжилд” Улаанбаатар хот, Говьсүмбэр аймагт “Хоршоод тогтвортой хөгжлийн төлөө” сургалт, туршлага судлах арга хэмжээнд хувийн зардлаар 6-27 ноос 7 дугаар сарын 3-ныг дуустал хугацаанд хамруулсан. . Аймгийн Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн 01/867 албан тоотыг хүлээн авч ХХС-ийн мэдээлэл 2023 оны эхний хагас жилд хийгдсэн ажлын бичвэр тайлан, ХХС-ийн чанаргүй зээлийн мэдээллийг 19 иргэний зээлийн үлдэгдэл “222511648 төгрөгийн” мэдээллийг, 2013-2018 онуудад томилогдсон 3 удаагийн сумын ИТХ-ын тогтоолыг, төсөл сонгон шалгаруулах хорооны ажлын хэсгийн 27 гишүүний мэдээллийг олж тус тус эксель пайлаар хүргүүлэв.

Засгийн газраас хэрэгжүүлж байгаа “Алсын хараа 2050” хөгжлийн хөтөлбөрийг сумын хэмжээнд 5 баг, 1 төсөвт байгууллагуудад сургалт хийж танилцуулсан.

УБ хотын орин суугч О.Баясгалантай Хамтран ажиллах гэрээ байгуулан дагуу сумын хэмжээнд нохой устгах арга хэмжээг зохион байгуулж сумын цагдаагийн тасгаас

заавар зөвлөгөө арга авч ажиллав. 2023 оны 7дугаар сарын 22-ны өдрөөс 2023 оны 7дугаар сарын 26-ныг дуустал 4 хоног ажилласан. Тус хугацаанд 121 золбин нохойг устгасан.

**Санхүүгийн чиглэлээр:** 2023 оны 7-р сарын орлогыг хааж тус онд олгосон санхүүжилтийг байгууллагын нягтлан бодогч нартай тулган баталгаажуулан ажилласан.

2023 оны 7-р сарын орлогыг хааж төвлөрүүлсэн.

1. Цалин, хөлс түүнтэй адилтгах орлого -359,141,443.61
2. Үйл ажиллагааны орлого – 1,634,792.66
3. Хөрөнгийн орлого -26,802,560.86
4. Шууд бус орлого – 77,055,820.14
5. Малын тоо толгойд ногдуулах албан татвар – 41,812,200
6. Бууны албан татвар – 624,000
7. ҮХХАТ- 15,374,783.35
8. Байгалын ургамлын нөөц ашигласны албан татвар – 2,023,900
9. Улсын тэмдэгтийн хураамж- 1,117,800
10. Хог хаягдлын үйлчилгээний төлбөр – 372,000
11. Газрын төлбөр- 51,606,917
12. Торгуулийн орлого –30,948,000 нийт 12 нэр төрлийн 608,514,217.62

төгрөгийн орлого төвлөрүүлэн хаалтыг хугацаанд хийж орлогыг 40%-ийн биелэлттэй төвлөрүүлэн ажиллаа. Аймгийн санхүүгийн дэмжлэг хувиараар 283,412,800 төгрөгийн санхүүжилт ирсэнээс орон нутгийн 3 байгууллага, ТЗШ-ын 5-н байгууллагад 799,568,900 төгрөгийн санхүүжилтийг олгож, 2023 оны 5-р сард 1025 ширхэг гүйлгээг хянаж батлан 5,123,759,255 төгрөгийн гүйлгээ хийгээд байна.

Төсөвт 7 байгууллага, Ерөнхий орлогын данс, 2 сан, ОНӨҮГ 1, Эргэлтийн эмийн сан 1, нийт 11 байгууллагын тайлангийн хугацаатай албан тоот хүргүүлэн тайланг хуулийн хугацаанд хүргүүлж ажилласан. 2023 оны Төсвийн төсөл, 2024, 2025 оны төсвийн төсөөлөлийг хүлээн авах албан тоотыг хүргүүлж ажиллаад байна. 2023 оны цалингийн шатлал нэмэгдсэнтэй холбогдуулан сангийн яаманд 7-р сарын баазад өөрчлөлт оруулан хуулийн өөрчлөлттэй холбоотой мэдээллүүдийг групп чатаар мэдээлж ажилласан

### **Мэдээлэл технологийн ажлын хүрээнд:**

- “Засаг даргын тамгын газар” пэйж хуудасаар дамжуулж цаг үеийн мэдээ мэдээллийг нийтэлж олон нийтийг мэдээллээр хангаж ажиллаа.

### **E-Mongolia.mn, Төрийн үйлчилгээний цахим системийн хүрээнд:**

Д/д	Үйлчилгээний тоо			Хамгийн их үзүүлсэн 10 үйлчилгээ	
	Нийт	Төлбөртэй	Төлбөргүй	Нэр	Тоо
1	5		3	Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт	3
2			5	Иргэний үнэмлэхийн лавлагаа	5
3			4	Иргэний оршин суугаа газрын хаягийн бүртгэлийн лавлагаа	4
4			3	Жолоочийн лавлагаа, мэдээлэл	3
<b>Нийт</b>		<b>0</b>	<b>15</b>		<b>15</b>

**Соёлын чиглэлээр.** Тулгар төрийн 2232 жил, Ардын хувьсгалын 102, Эрдэнэцагаан сум үүсгэн байгуулагдсаны 99 жилийн ойн баяр наадмын нээлт, хаалтын үйл ажиллагаанд Соёлын төвийн дэргэдэх дуу хөгжим, бүжгийн дугуйлангийн 30 сурагч, ардын авъяастан-23, соёлын төвийн ажилчин албан хаагчид, хилийн 0146-р ангийн 5 албан хаагч,зэрэг нийт 58 хүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулан ажилласан.

**Мал эмнэлэгийн тасаг:** Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2023 оны А/32 тоот тушаал ХХААХҮС-ын 2023 оны А/02 тушаал, Сумын Засаг даргын 2023 оны 05дугаар асрын 03-ны өдрин А/78 тоот захирамжийн дагуу Гоц халдварт Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлээд байна. Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээнд 6 ажлын хэсэг, туслах ажилтан-10, малын эмч- 8, санитарч-2 нийт-26 ажилласан. Сумын хэмжээний өвчлөмтгий нийт 40219 үхэр сүргийг хамруулж хэвийн хорогдол 481 мл устгаад байна. Шүлхийн дархлаажуулалтын материалыг дүн мэдээг нэгтгэн сумын Засаг даргаар баталгаажуулан, Вакцины шил савыг хүлээн авч Аймгийн мал эмнэлгийн газарт хүлээлгэж өгсөн.

Сумын Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 14-ны өдрийн А/119 тоот захирамжийн дагуу Ажлын хэсгийн ахлагчаар Тамгын газрын дарга У.Мөнхцэцэг, Гишүүд Багийн Засаг дарга нар, Санхүү албаны дарга- Х.Шинэцэцэг, Хөдөө аж ахуйн мэргэжилтэн –Б.Ганхуяг, татварын байцаагч- П.Одончимэг, Мал эмнэлгийн тасаг хамтран ажиллалаа. Хяналт шалгалтын явцад 1р багийн -13 өрх, 4-багийн 10 өрх, 6 багийн – 10, 7багийн- 45 нийт -78 өрхөөр орж, малын эрүүл мэндийн дэвтэрт бичилт хийсэн эсэхийг үзэж, Санхүү албаны дарга Х.Шинэцэцэг Суманд болж байгаа цаг үеийн мэдээ мэдээллийг хүргэж, мал эмнэлгийн ажил үйлчилгээний талаар иргэдийн санал хүсэлтийг сонслоо.

Тайлан бичсэн: ХЭЗ,ХШҮ- хариуцсан мэргэжилтэн Д.Жагварал.